

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2022/150/НА-СА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn


Дархан-Уул аймаг
2022 он

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудиторын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч:
Ш.Мөнхбаяр
Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батцэцэг
Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Ахлах аудитор: Х.Сувдмаа
Утас: 70373089 Цахим хаяг: Suvdmaakh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,079,770,055.41	4,034,409,922.70
	Мөнгөн хөрөнгө	-	423,183.14
	Авлага	-	2,802,600,490.00
	Бараа материал	1,079,770,055.41	1,29,286,249.56
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	-	-
	Нийт хөрөнгийн дүн	17,722,648,371.43	26,383,584,534.61
	Нийт өр төлбөрийн дүн	-	1,467,690,436.36
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	-	-
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	17,722,648,371.43	26,381,484,534.61
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	16,434,123,653.93	29,534,642,949.99
	Үйл ажиллагааны зардлын дүн	16,137,600,614.37	22,341,250,184.27
	Үйл ажиллагааны үр дүн	296,523,039.56	7,193,392,765.72
	Үйл ажиллагааны бус үр дүн	3,388,597.03	2,247,038.90
	Үйл ажиллагааны нийт үр дүн	293,134,442.53	7,191,145,726.82
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,626,717,083.16	17,727,363,772.78
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(4,715,401,635)
	Тайлант оны үр дүн	-	7,191,145,726.82
	Эцсийн үлдэгдэл	7,626,717,083.16	24,913,794,098.25
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	14,394,161,321.00	17,857,476,841.00
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	13,957,471,421.00	17,818,808,757.86
	Үйл ажиллагааны ЦМГ	436,689,900.00	38,688,083.14
	Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн	436,689,900.00	38,244,900.00
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(436,689,900.00)	(38,244,900.00)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	423,183.14
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	423,183.14
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	18,451,343,800.00	16,166,453,716.86
	Урсгал зардал	18,451,343,800.00	16,166,876,900.00
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	18,451,343,800.00	16,166,876,900.00
	Улсын төсвөөс санхүүжих	1,156,103,000.00	1,156,103,260.00
	ЭМД-ын сангаас	17,005,659,000.00	14,721,192,315.00
	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос	289,581,800.00	289,581,325.00

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Нэгдсэн **ЭМНЭЛЭГ НЬ** "Эмнэлгийн удирдлага, манлайлалыг дээшлүүлж, хүний нөөцийн ур чадварыг сайжруулж, техник технологи, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын тогтолцоог үр дүнтэй нэвтрүүлэн, эрүүл мэндийг

хамгаалах, дэмжих, зохион байгуулах үйлчилгээг олон улсын жишигээр хөгжүүлэх” зорилгын” гэсэн зорилтыг дэвшүүлжээ.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Дөрөв. Аудитын гол асуудал

Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн 6 дугаар зүйлд заасантай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар тайлант онд ЭМД-ын сангаас авах 2,802,600.5 мянган төгрөгийн авлага орж ирээгүйгээс 1,467,690.4 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна. Цаашид ЭМД-ын сантай төлбөр тооцоог тухай бүрд нь нийлж, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 6,947,26,748,538.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 6,000,2131,051.8 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 947,0483.8 мянган төгрөгийн төлбөрийн акт, 4,463,093.6 мянган төгрөгийн албан шаардлага, 2,153,908.9 мянган төгрөгийн зөрчилд 42 зөвлөмж өгөв. Үүнд:

1. Цалингийн зардлын данстай Хууль тогтоомжтой холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тус байгууллага нь 2021 оны 3 дугаар сараас ЭМДҮЗ-ийн 3 дугаар тогтоолын дагуу хагас бие даасан байдал руу шилжсэн боловч Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/334 тушаалын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийг одоог хүртэл байгуулаагүй байна. Тус байгууллагын архив-бичиг хэргийн ажилтан, нярвын ажил үүргийг хавсран гүйцэтгэж байгаа 2 ажилтанд үндсэн ажлын албан тушаалын цалингаас хавсран ажилласны нэмэгдлийг тооцон олгосон. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д “Ажилтны цалин хөлсийг хийснээр, ... хөдөлмөрийн үр дүнд нь төхчруулан өлгөнө” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/334 тушаалын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулж, эрх үүргийг хэрэгжүүлэх Архив-бичиг хэргийн ажилтан, нярвын ажил үүргийг хавсран гүйцэтгэж буй 2 ажилтанд дээрх албан тушаалын цалингийн сүлжээнээс хавсран ажилласны нэмэгдлийг тооцон өлгөх.

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Эрүүл мэндийн сайдын А/725 дугаар тушаалаар тус байгууллагад 169,335.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 14,573.1 мянган төгрөгийн материалыг хуваарилсан боловч ирээгүй мөн тушаал шийдвэргүйгээр 1,970,000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө ирсэн байна.

Formatted: Font: (Default) Arial, Font color: Black

Formatted: Font: (Default) Arial

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20.2.5 дахь заалтуудыг хэрэгжүүлж, ЭМЯ-аас шилжүүлж буй хөрөнгийг тухай бүрд нь тооцоо нийлж, авлага, өр төлбөргүй ажиллах

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчлгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

(сая төгрөгөөр)

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	ТШЗ	4	2,285.5	1	131.1	1	0.5			2	2,153.9
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн	4	2,285.5	1	131.1	1	0.5			2	2,153.9
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	ТШЗ	1	4,463.1					1	4,463.1		
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн	1	4,463.1					1	4,463.1		
	НИЙТ ДҮН	5	6,748.6	1	131.1	1	0.5	1	4,463.1	2	2,153.9

